

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2011-06-02/**

Ажлын хэсгийн хуралдаан 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 17 цаг 10 минутад Ашигт малтмалын газрын хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, ажлын хэсгийн гишүүн Авилгатай тэмцэх газрын хэлтсийн дарга Д.Дуламсүрэн, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Инфорум төвийн тэргүүн А.Батпүрэв, Миний Монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн Б.Болдбаатар, Монголын байгаль орчны ТББ-уудын холбооны ерөнхийлөгч Б.Батболд, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, мөн Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын мэргэжилтэн Д.Бүувэйжаргал, Газрын тосны газрын хөрөнгө оруулалтын хяналтын тасгийн дарга Э.Оюун, Үндэсний татварын ерөнхий газрын тусгай хяналтын тасгийн дарга Я.Пүрвээ, улсын төсвийн орлого хяналтын газрын эрдэс баялгийн татварын хэлтсийн ахлах байцаагч Т.Цэцэгням, байцаагч Энхтуяа, Ашигт малтмалын газрын уул уурхайн судалгааны хэлтсийн статистик мэдээлэл, судалгааны тасгийн мэргэжилтэн Б.Сүхтулга, Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч Г.Лхагва-Очир, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн захирлын зөвлөх Б.Эрдэнэдорж, Монголпросцветмет ХХК-ийн ерөнхий нябо Д.Номинзул, МАК ХХК-ийн менежер Өлзийдэлгэр, Монголын ажил олгогч эздийн холбооны бизнесийн харилцааны албаны дарга Б.Жанцан, Нуурс ассоциацийн менежер Э.Сарангэрэл, Нээлттэй нийгэм форумын ажилтан Б.Алтанчимэг нар оролцов.

Мөн хуралдаанд Гаалийн ерөнхий газрын санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга М.Өлзийбат, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ерөнхий захирал Б.Осограав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Мэндбаяр, аудитор Ч.Номинчулуун, ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон хуралдаанд ажлын хэсгийн 25 гишүүнээс 19 гишүүн оролцож, ирц 76 хувьтай байгаа тухай болон оролцогчдыг нэг бүрчлэн танилцуулав.

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор нээж, Сайн байцаанаа уу! Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаанаар бид 3 асуудал хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн явц, эцсийн дүгнэлтүүд, хоёрдугаарт, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын болон Ерөнхий сайдын захирамжийн төсөл, гуравдугаарт, Монгол Улсын ОҮИТБС-ыг 2012 онд хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжүүлэх зарим зардлын тооцооны тухай гэсэн асуудлуудыг авч хэлэлцэнэ. Дараа нь хурлын дотоод журмын төслийг танилцуулж, хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмын талаар гишүүдийн зөвшөөрлийг авснаар хуралдааныг эхлүүлэв.

**I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлангийн явц, эцсийн дүгнэлтүүд**

Танилцуулгын эхэнд “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргаав Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны тайлангийн нэгтгэлийн ерөнхий танилцуулгыг хийж, ажлын хэсгийн 2011 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэхэд 2,4 тэрбум төгрөгийн шийдэгдээгүй зөрүүтэй байсан тухай, ажлын хэсгийн хуралдаанаас хойш сар гаруй хугацаанд Засгийн газрын холбогдох яам, агентлагууд, компаниудтай хамтран ажиллаж, өнөөдрийн байдлаар шийдэгдээгүй зөрүү нь 77,4 сая төгрөг бүхий нэгтгэл тайланг та бүхэнд танилцуулахаар бэлдээд байна. Аудитын нэгтгэлийн ажлын эцсийн дүгнэлтийн талаар ахлах аудитор Н.Эрдэнэцог та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулга хийнэ гэв.

“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ахлах аудитор Н.Эрдэнэцог Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2009 оны нэгдсэн тайлангийн явц, шийдэгдээгүй зөрүү, өгч байгаа зөвлөмжийн талаар танилцуулав (Танилцуулгыг хавсаргав).

Б.Долгор: За баярлалаа. Асуух асуулт байна уу? Өмнөх онд тайланд хамрагдсан компаниудийг шийдвэрлэгдээгүй зөрүү нь энэ онд нэмэгдсэн байна уу, буурсан байна уу гэх зэргээр харьцуулж үзсэн судалгаа, дүгнэлт байна уу?

Н.Эрдэнэцог: Өмнөх оны тайланд хамрагдсан компаниудын хувьд энэ жил их цөөхөн компани дээр зөрүү үлдсэн байгаа, ихэнх нь шинэ компаниуд энэ жил нэгтгэлд орсон байгаа.

Б.Долгор: Хэдэн компани байна вэ?

Б.Осоргаав: 2008 оны нэгтгэлд орсон компаниудаас 9 компани дээр энэ жил зөрүү үлдсэн байгаа. Бусад зөрүү нь бол шинэ компаниуд дээр гарсан. Дахин давтан зөрүү гарсан 9 компани байна.

Б.Долгор: Түүний шалтгаан юу байна вэ?

Б.Мэндбаяр: Хандив тусlamж болон байгаль хамгаалах 50 хувийн зардалтай холбоотойгоор зөрүү үүссэн. Хандив тусlamжийн тухайд компаниуд төлсөн гэдгээ анхан шатны баримтаар нотолж байхад нөгөө талаас ийм хандив тусlamж аваагүй болно гээд албан бичиг ирүүлээд байгаа. Энэ тохиолдолд зөрүүг аль талд шийдвэрлэх вэ гэдгийг шийдэхэд бидэнд хүндрэлтэй байгаа.

Б.Долгор: Засгийн газрын байгууллагуудын тухайд ямар сайн тал, дутагдалтай асуудлууд байна вэ?

Б.Осоргаав: Шийдвэрлэгдээгүй 77,4 сая төгрөгийн зөрүүний тал хувь нь БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газар дээр гарч ирж байгаа. Бусад байгууллагуудын хувьд харьцангуй гайгүй. Татварын ерөнхий газрын тухайд зөрүүний учрыг нь олчих юмсан гэсэн сэтгэлээр хандаж, маш идэвх зүтгэлтэй ажиллаж, бид хамтран ажиллахад их таатай байлаа. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын тухайд даргатай нь өөрийн биеэр очиж уулзаж шийдвэрлэгдээгүй зөрүү дээр протокол үйлдсэн. Харин Ашигт малтмалын газрын хувьд энэ үйл ажиллагаанд ач холбогдол бага өгч, их хойрго хандаж байлаа. Тухайлбал өмнөх ажлын хэсгийн хуралдааны талаар хуралд төлөөлөн оролцсон

хүн нь цааш мэдээлэл хийгээгүй юмуу, ямар нэг шалтгааны улмаас бид 2,4 тэрбумын шийдвэрлэгдээгүй зөрүүний талаар холбогдоход учир дутагдалтай хандаж, бидний ажилд хүндрэл учруулж байлаа. Ашигт малтмалын газар өмнөх онуудад сонин, нийтлэлээр дамжуулж ОҮИТБС-ыг олон нийтэд сурталчилж байсныг хараад их дэмжиж ажилладаг юм байна гэж ойлгож байсан боловч аудит хийх үеэр энэ байдал нь ажиглагдсангүй. Гэхдээ энэ нь тухайн ажил хариуцсан хүнээс шалтгаалдаг байх, түүнээс АМГ-ыг тэр чигээр нь муу ажилласан гэж байгаа юм биш шүү.

Б.Долгор: Асуулт байна уу?

Б.Жанцан: Тайланд нэгтгэгдсэн 101 компаниас 22 компани дээр 77 сая төгрөгний шийдвэрлэгдээгүй зөрүү үлдсэн байна гэж ойлгож болох уу?

Б.Осоргарав: Тийм. Ихэнх дээр нь бид нар протокол үйлдсэн, холбогдох албан бичгийг авсан байгаа. Өнгөрсөн 2008 оны тайлан 410 сая төгрөгний шийдвэрлэгдээгүй зөрүүтэй үлдэж байсан бол энэ жил 77,4 сая төгрөгний зөрүү яах ч аргагүй мухардаж үлдлээ гэж хэлэх байна.

Ш.Цолモン: Эрдэс баялгийн яамтай холбоотой хандив шийдвэрлэхгүй үлдэж байна гэж байсан. Энэ юу болсон бэ?

Б.Мэндбаяр: “Дацан трейд” ХХК нэг сая төгрөгний хандив ЭБЭХЯ-нд өгсөн гээд энэ шийдвэрлэхгүй үлдсэн байгаа, энэ талаар бид яам руу албан бичиг явуулсан боловч хариу ирүүлээгүй байна. Бид тус яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү даргатай уулзаж тухайн үед ойн арга хэмжээний комиссын дарга байсан Эрдэнэцэцэг гэдэг хүнтэй холбогдоорой гэж заавар чиглэл өгсөн. Энэ дагуу бид Эрдэнэцэцэг рүү залгасан боловч утас нь холбогдохгүй байгаад байна. Нөгөө талаас Ашигт малтмалын газарт өгсөн хандив тусламж шийдвэрлэхгүй үлдсэн. Компаниуд нь өгснөө нотолсон боловч АМГ-ын мэдээллийн баазаас гарч ирэхгүй байна гэсэн албан бичиг ирүүлсэн, энэ хандив шийдвэрлэхгүй үлдсэн байгаа.

Б.Болдбаатар: Тэр нь хичнээн хэмжээний төгрөг байна вэ?

Б.Мэндбаяр: “Олон овоот гоулд” ХХК-ийн өгсөн 3 сая төгрөгний хандив, “Бэрэн групп” ХХК-ийн өгсөн 5 сая төгрөгний хандив нийт 8 сая төгрөгний хандивын асуудал байна.

Б.Долгор: За Ашигт малтмалын газраас хэн хуралд оролцож байна вэ? Тэр хүн асуултад хариулахгүй юу? Ашигт малтмалын газрыг хамтран ажиллахад хүндрэлтэй байлаа гэж байна, цаашид ер нь яаж ажиллах юм?

Б.Сүхтулга: “Улаанбаатар аудит корпораци” ХХК руу нэг албан бичиг явуулсан байгаа.

Б.Мэндбаяр: За тэр албан бичигт боломжийнхоо хирээр мэдээлэл шүүлээ, гэвч манай мэдээллийн баазаас энэ талаар нотлох баримт гарч ирэхгүй байна гэсэн албан бичиг ирүүлсэн байгаа. Гэтэл АМГ-ын хэлтсийн дарга нар өөрсдөө тухайн компаниуд руу хүсэлт тавьсан албан бичиг хүртэл явуулсан нь нотлогдоод

байгаа, нөгөө талаас компаниудын анхан шатны баримтаас үзэхэд хандив өгсөн нь нотлогдоод байгаа. Гэтэл одоо мэдээллийн баазаас гарч ирэхгүй байна гэсэн хариу өгөөд байгаа.

Б.Сүхтулга: Манай газар 2011 оны 5 сарын 25-ны байдлаар албан бичиг өгсөн. Үүгээр 2009 оны лицензийн төлбөр хураамж, хандив тусламж гэх зэрэг шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүнүүд дээр тайлбар өгсөн байгаа.

Б.Долгор: Яасан гэнэ ээ? Юу ч сонсогдсонгүй, ойлгогдохгүй байна.

Б.Сүхтулга: За зөрүү үүссэн компани болгоноор нь тайлбарлаад явъя. “Оюу толгой” ХХК, “Эрдэс холдинг” ХХК, “МАК” компани, “Коммод” ХХК гээд 4 компани байна.

Б.Жанцан: 2 компанийн тухайд л асуугаад байгаа юм биш үү.

Б.Долгор: Хандив өгсөн гэсэн 2 компанийн 8 сая төгрөг дээр тайлбар хийхгүй юу?

Б.Сүхтулга: Тэрийг гайхаад байна. Би яг сайн мэдэхгүй юм байна.

Б.Долгор: Ашигт малтмалын газраас яг ямар хариу өгсөн юм?

Б.Мэндбаяр: Энэ талаар хандивын мэдээлэл байхгүй байна л гэсэн байсан.

Б.Долгор: Хэний гарын үсэгтэй бичиг байна вэ?

Б.Мэндбаяр: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Б.Түвшинжаргал гэдэг хүний гарын үсэгтэй албан бичиг ирүүлсэн.

Б.Долгор: За өөр асуулт асуух хүн байна уу?

Т.Цэцэгням: ОҮИТБС маягт 3-ыг Татварын ерөнхий газар нэгтгэнэ гэсэн байх юм, энэ бол Газрын тосны чиглэлээр гаргадаг маягт биш билүү, үүнийг тодруулах гэсэн юм.

Ш.Цолмон: Энэ дээр андуураад бичсэн байна гэж би ойлгосон. Маягт 4, 5, 6 гэж байх ёстой. Хуучин маягтаар бол 3 дугаар маягтыг ТЕГ нэгтгэнэ, шинэчилсэн маягтаар 3-аар газрын тосны компаниуд тайлан гаргаж байгаа.

Б.Болдбаатар: Сум орон нутагт хандив тусламж өгдөг. Тухайлбал “Болд төмөр ерөө гол” ХХК өнгөрсөн жил Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 200 сая төгрөгний хандив өгсөн байгаа юм. Гэтэл үүний зарцуулалтын талаар ерөөсөө тайлан гаргаж өгдөггүй, биднийг энэ талаар асуухаар та нарт гаргаж өгөх албагүй гээд сууж байдаг. Үүнийг яах ёстой вэ?

Н.Алгаа: Бид нар зөрүү гарч байна уу гэдгийг шалгахаас биш зарцуулалт дээр хяналт тавихгүй. Үүнийг орон нутгийн иргэд хийх ёстой. Бидний энэ тайлан нэгтгэлийн ажилтай холбоогүй асуудал гэж ойлгож байна.

Б.Болдбаатар: Холбоогүй боловч иргэний нийгэм талаасаа хараад энэ бол авилгалын асуудал явж байна.

Б.Долгор: Бидний гол хийх ажил бол хандив авсан юм байна гэдгийг аудитороор баталгаажуулсан тоо мэдээг олон нийтэд мэдээлэх явдал юм. Харин орон нутгийн иргэд энэ мэдээлэлд тулгуурлан хяналтаа тавих ёстой.

Б.Осоргарав: Гаалийн ерөнхий газар энэ жилийн тайланда маш өндөр ач холбогдол өгч, бидэнтэй маш сайхан хамтран ажилласан. Тэгэхээр Гаалийн ерөнхий газрыг төлөөлөн ирсэн тус газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга М.Өлзийбатад талархлаа илэрхийлмээр байна.

Б.Мэндбаяр: Ашигт малтмалын газрын санхүү, эдийн засгийн хэлтсээс бүх тоо мэдээ гарч байдаг. Тиймээс тэр хэлтсээс энэ хуралд оролцдог байх нь зүйтэй юм болов уу гэсэн саналтай байна.

Б.Осоргарав: Дээр нь нэмж хэлэхэд Засгийн газрын тогтоолын төсөл явж байгаа юм байна. Үүн дээр ОҮИТБС-ын ажлын албаны нэр томъёог өөрчлөх талаар тусгаж өгнө үү гэж хүсэх байна. Компаниуд энэ ажлын албыг өр нь бол хүлээн зөвшөөрдөггүй.

Б.Долгор: Гол нь зөв ойлгуулах л асуудал шүү дээ. Угаасаа энэ Санаачлагаар Ерөнхий сайдын ахалсан Үндэсний хороо ажилладаг. Үүнийгээ компаниудад дутуу ойлгуулаад, бланк энэ тэрээ ойлгомжгүй гаргаад байгаа бол бид нарын л муугийнх. За өөр асуух асуулт байна уу? Байхгүй бол санал байна уу?

Н.Алгаа: ОҮИТБС-ын 4 дэх жилийн тайлан гарч байна. Хамгийн анхны тайлангийн зөрүү 25 тэрбум байсан. Энэ жилийнхэд хамрагдах компанийн тоо 4 дахин нэмэгдсэн бол, зөрүү нь 300 дахин багассан байна. Тэгэхээр ерөнхий том зургаар нь авч үзвэл бид үр дүнтэй сайн ажиллаа гэсэн дүгнэлттэй байна. 2 жил дараалан ажиллахдаа “Улаанбаатар аудит корпораци” ХХК арга барилаа олж, үр дүн хурсэн юм болов уу. Хоёрдугаарт, Улаанбаатар аудитын тавиад байгаа саналыг би бас 2 жил дэмжээд байгаа юм. Яг ил тод байдлын санаачлага гэхээр машины хураамж, бууны хураамж зэргийг бүгдийг нь ил тод болгоно гэхээр хэтэрхий үр дүнгүй, том асуудлаа жижиг зүйлээр булаад байгаа юм биш биз гэсэн болгоомжпол төрж байна. Ялангуяа энэ хураамж, үйлчилгээний хөлс, тэмдэгтийн хураамж зэргийг материаллаг байдлаасаа буюу маягтаас хасаад өгвөл ажил их цэгтэй, хурдан явмаар юм шиг харагдаж байна. Хандив дээр мөн адил 200-300 мянгаар өгсөн хандив байдаг байх, 10-20 мянгаар ч өгсөн хандив байдаг байх. Үүнийг бас тоон дүн дээр нь бодолцож үзэх хэрэгтэй юм шиг. Тэр болгонд хойноос нь утасдаад, ингээд хөөцөлдөөд байх нь хүндрэлтэй юм болов уу. Эдгээрийг нэг бодолцож үзээчээ гэсэн санал байна. За санаачлагын хэрэгжилтийн тухайд компаниудыг төлөөлөөд сууж байгаагийн хувьд сайн явж байна гэж хэлэх байна.

Б.Жанцан: ОҮИТБС хэрэгжиж эхлээд 4 удаагийн тайлан гаргаж байна. Тэгэхээр миний хэлэх гэж буй гол санал бол энэ тайланда идэвхтэй оролцдог, тайлангаа үнэн зөв гаргадаг компаниудыг хэвлэл мэдээллээр сайн сурталчилж өгвөл ясан юм бэ гэсэн саналтай байна. Нөгөө талаас хандив тусламж авчихаад

тайлан өгөхгүй байвал энэ талаар бас ил тод нийтэд мэдээлэх хэрэгтэй. Эхгүй бол байж байгаад л бид хэд нэг хуралддаг, зөрүү л яриад байдаг. Яг сан хэмжээнд тэр оролцогч талуудад ямар хэрэгтэй нь мэдэгдэхгүй байгаад байна. Тиймээс төсөв дээрээ сурталчилгааны зардал тусгаад явая гэсэн юналтай байна.

Э.Сумъяа: За тайлантай холбоотой хоёр, гурван санал хэлье. Өмнөх яжлын хэсгийн хуралдаанаас хойш аудитын компани сайн ажилласан байна. Засгийн газрын агентлагуудын ажлыг сайжруулах зорилгоор Б.Долгор дарга холбогдох ажилтнуудыг цуглуулж тодорхой үүрэг чиглэл өгсөний үр дүнд төрийн байгууллагууд бас сайн ажиллажээ гэсэн дүгнэлттэй байна. "Улаанбаатар аудит корпораци" ХХК болон "Харт Нойрс" компанийн консорциум энэ жилийн тайландач холбогдол өгч, өнгөрсөн оны тайланд гардаг ерөнхий зөвлөмжүүдээс илүү нарийвчилсан зөвлөмж рүү орсон, шийдвэрлэгдээгүй зөрүүний учир шалтгааныг, оршиж байгаа гол гол дутагдлыг илрүүлсэн ийм тайлан болжээ гэдгийг тэмдэглээ. Аудитын компаниас өгч буй зөвлөмжтэй холбоотойгоор хэдэн санал хэлье. Нэгдүгээр зөвлөмжтэй холбогдуулаад ажлын албыг Ерөнхий сайдын дэргэдэх, эсхүл Засгийн газрын дэргэдэх ОҮИТБС ажлын алба гэсэн саналыг оруулмааргүй байна. Учир нь ажлын алба бол манай түншлэгч компани, иргэний нийгэм, Засгийн газар гэсэн оролцогч гурван талын дундын ажлын алба юм. Засгийн газрын ажлын алба гэчихээр нөгөө хоёр талыгаа үгүйсгэсэн болчих гээд байна. Ер та бүхэн ажлын албаны нэр хүндийг өсгөх чиглэлээр зөвлөмж өгч болно, гэхдээ яг Засгийн газрын дэргэдэх ч гэх юмуу ийм зөвлөмж өгмөөргүй байна, энэ талаар бодолцож үзээчээ гэх гэсэн юм. Хоёрдугаарт, орон тоог нэмэгдүүлэх зөвлөмж өгсөн байна. Бид ажлын албаны орон тоог З болгохоор Дэлхийн банкинд саналаа тавьчихсан байгаа. Гуравдугаарт, материаллаг байдлын түвшин дээр та бүхэн ялангуяа аудитын компани их тодорхой санал хэлмээр байна. Бид энэ асуудлыг гардаж хийдэггүй учраас зарим нарийн зүйлийг мэдэхгүй байна, харин аудитын компани тулж ажиллаж байгаагийнхаа хувьд яг ямар асуудал тулгарад байна, тэр талаараа бидэнд саналаа гаргаад өгөх, бид түүнтэй танилцаж байгаад материаллаг байдлын одоогийн мөрдөж байгаа жишгийг өөрчилж болно ос Тайлан бол нилээн дэлгэрэнгүй ирэх байх, тайланг хүлээж аваад Үндэсни зөвлөлийн хуралд оруулахдаа холбогдох яам, агентлагаар тайлбарыг гаргуулж болно. Тиймээс та бүхэн эцсийн тайлангаа бидэнд аль болох хурдан ирүүлээрээ За шийдвэрлэгдээгүй цэвэр зөрүү гэсэн нэр томъёо үе шат болгонд яваад байг юм. Анх тайланг нэгтгэхэд шийдэгдээгүй зөрүү 70 гаруй тэрбум, дараа нь ажл хэсгийн хуралдаанаар тайлан хэлэлцэх нэгдүгээр хуралдаан дээр шийдэгдээ зөрүү 2,4 тэрбум, одоо шийдвэрлэгдээгүй цэвэр зөрүү нь 77,4 сая болчих байж байна гэж байна. Тэгэхээр үүнийгээ нэг тодорхой болгоод өгөөчээ. Энэ с шийдэгдээгүй зөрүү гэсэн үг хүмүүсийн толгой эргүүлээд байна л даа. Ийм шат болгоны зөрүүг өөр өөрөөр нэрлэх, тухайлбал, хоёр талын тайланг нэгтгэхэд гарсан зөрүү, Ажлын хэсгийн хуралдаанд тайлан хэлэлцүүлэхэд баг зөрүү гэж нэрлэх, харин хамгийн сүүлд үлдсэн зөрүү бол шийдэгдээгүй зөрүү жишээтэй. Тайланг эцэслэн гаргахдаа та бүхэн үүн дээр нэг анхаараачээ саналтай байна. За баярлалаа.

Б.Долгор: За өөр санал байна уу?

Т.Цэцэгням: За аж ахуйн нэгж төлсөн гээд байхад татварын мэдээлэлд байхгүй байна гэсэн 3 компанийн асуудал байна. Энд бол зөрө

ер тайлан өгөхгүй байвал энэ талаар бас ил тод нийтэд мэдээлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол байж байгаад л бид хэд нэг хуралддаг, зөрүү л яриад байдаг. Яг улсын хэмжээнд тэр оролцогч талуудад ямар хэрэгтэй нь мэдэгдэхгүй байгаад байна. Тиймээс төсөв дээрээ сурталчилгааны зардал тусгаад явая гэсэн саналтай байна.

Э.Сумъяа: За тайлантай холбоотой хоёр, гурван санал хэлье. Өмнөх ажлын хэсгийн хуралдаанаас хойш аудитын компани сайн ажилласан байна. Засгийн газрын агентлагуудын ажлыг сайжруулах зорилгоор Б.Долгор дарга холбогдох ажилтнуудыг цуглуулж тодорхой үүрэг чиглэл өгсөний үр дүнд төрийн байгууллагууд бас сайн ажиллажээ гэсэн дүгнэлттэй байна. “Улаанбаатар аудит корпораци” ХХК болон “Харт Нойрс” компанийн консорциум энэ жилийн тайланд ач холбогдол өгч, өнгөрсөн оны тайланд гардаг ерөнхий зөвлөмжүүдээс илүү нарийвчилсан зөвлөмж рүү орсон, шийдвэрлэгдээгүй зөрүүний учир шалтгааныг, оршиж байгаа гол гол дутагдлыг илрүүлсэн ийм тайлан болжээ гэдгийг тэмдэглээ. Аудитын компаниас өгч буй зөвлөмжтэй холбоотойгоор хэдэн санал хэлье. Нэгдүгээр зөвлөмжтэй холбогдуулаад ажлын албыг Ерөнхий сайдын дэргэдэх, эсхүл Засгийн газрын дэргэдэх ОҮИТБС ажлын алба гэсэн саналыг оруулмааргүй байна. Учир нь ажлын алба бол манай түншлэгч компани, иргэний нийгэм, Засгийн газар гэсэн оролцогч гурван талын дундын ажлын алба юм. Засгийн газрын ажлын алба гэчихээр нөгөө хоёр талыгаа үгүйсгэсэн болчих гээд байна. Ер та бүхэн ажлын албаны нэр хүндийг өсгөх чиглэлээр зөвлөмж өгч болно, гэхдээ яг Засгийн газрын дэргэдэх ч гэх юмуу ийм зөвлөмж өгмөөргүй байна, энэ талаар бодолцож үзээчээ гэх гэсэн юм. Хоёрдугаарт, орон тоог нэмэгдүүлэх зөвлөмж өгсөн байна. Бид ажлын албаны орон тоог З болгохоор Дэлхийн банкинд саналаа тавьчихсан байгаа. Гуравдугаарт, материаллаг байдлын тувшин дээр та бүхэн ялангуяа аудитын компани их тодорхой санал хэлмээр байна. Бид энэ асуудлыг гардаж хийдэггүй учраас зарим нарийн зүйлийг мэдэхгүй байна, харин аудитын компани тулж ажиллаж байгаагийнхаа хувьд яг ямар асуудал тулгараад байна, тэр талаараа бидэнд саналаа гаргаад өгөх, бид түүнтэй танилцаж байгаад материаллаг байдлын одоогийн мөрдөж байгаа жишигийг өөрчилж болно оо. Тайлан бол нилээн дэлгэрэнгүй ирэх байх, тайланг хүлээж аваад Үндэсний зөвлөлийн хуралд оруулахдаа холбогдох яам, агентлагаар тайлбарыг гаргуулах болно. Тиймээс та бүхэн эцсийн тайлангаа бидэнд аль болох хурдан ирүүлээрэй. За шийдвэрлэгдээгүй цэвэр зөрүү гэсэн нэр томъёо үе шат болгонд яваад байгаа юм. Анх тайланг нэгтгэхэд шийдэгдээгүй зөрүү 70 гаруй тэрбум, дараа нь ажлын хэсгийн хуралдаанаар тайлан хэлэлцэх нэгдүгээр хуралдаан дээр шийдэгдээгүй зөрүү 2,4 тэрбум, одоо шийдвэрлэгдээгүй цэвэр зөрүү нь 77,4 сая болчихоод байж байна гэж байна. Тэгэхээр үүнийгээ нэг тодорхой болгоод өгөөчээ. Энэ олон шийдэгдээгүй зөрүү гэсэн үг хүмүүсийн толгой эргүүлээд байна л даа. Иймд үе шат болгоны зөрүүг өөр өөрөөр нэрлэх, тухайлбал, хоёр талын тайланг анх нэгтгэхэд гарсан зөрүү, Ажлын хэсгийн хуралдаанд тайлан хэлэлцүүлэхэд байсан зөрүү гэж нэрлэх, харин хамгийн сүүлд үлдсэн зөрүү бол шийдэгдээгүй зөрүү байх жишээтэй. Тайланг эцэслэн гаргахдаа та бүхэн үүн дээр нэг анхаараачээ гэсэн саналтай байна. За баярлалаа.

Б.Долгор: За өөр санал байна уу?

Т.Цэцэгням: За аж ахуйн нэгж төлсөн гээд байхад татварын албаны мэдээлэлд байхгүй байна гэсэн 3 компанийн асуудал байна. Энд бол зөрөх 2 зам

бий. Нэг бол тэр мөнгө ороод будлиад алга болсон, нэг бол андуурсан, тиймээс тэр компанийн төлсөн мөнгөний баримтыг бидэнд ирүүлвэл бид банкин дээр очоод будлиад явчихаж уу, аль эсхүл татварын албаны мэдээллийн баазад оруулахдаа андуурсан байна уу гэдгийг тодруулая гэсэн санал тавиад байгаа юм. Тэгэхээр энэ З компанийн хувьд тийм баримт ирээгүй тул тодруулах боломжгүй байсан. Тиймээс аудитын компани тухайн байгууллагуудаас тодруулгыг нь гаргуулаад өгвөл бид ямар ч замаар шалгах боломжтой тул энэ З компанийн асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Д.Бүүвэйжаргал: За санаачлага маань сайн ажиллаж байна гэж түрүүнд Н.Алгаа дарга хэлсэн, бид давхардуулж хэлээд яахав. Санаачлагын талаар буруу зөрүү ойлголт яваад байгаа. Миний хувьд компаниуд тайлангаа гаргадаг болсон нь маш том алхам гэж үзэж байна. Тэгэхээр сурталчилгааг эхлээд эерэг талаас нь явуулах, дараа нь үе шаттайгаар сөрөг сурталчилгааг аажмаар явуулахгүй бол компаниудыг үргээчих вий, буруу ойлголт төрүүлэх вий гэсэн болгоомжлол байна. Зөв талын сурталчилгааг их хийе, хүмүүс хэвшсэн хойно буюу дараа нь тэр шийдвэрлэгүй зөрүү, түүний үүссэн шалтгааны тухай сурталчилгааг явуулах нь зүйтэй юм болов уу гэсэн саналтай байна.

Б.Долгор: За баярлалаа. Хүмүүсийн саналтай нэг байна. Тайлан гаргаж байгаа аудитын компани маань хоёр дахь жилдээ ажиллаж, сайн тайлан гаргалаа гэсэн дүгнэлттэй байна. Ялангуяа тайлан гаргах явцад илэрч байгаа зөрчилтэй асуудлуудыг, цаашид боловсронгуй болгох ёстой, шийдвэрлэх ёстой асуудлууд дээр зөвлөмж гаргаж байгаа нь их хэрэгтэй байгаа. Энэ ч үндсэн дээр тайлан гаргах ажлуудыг цэгцлээд явсны үр дүнд, бидний ажилд нааштай үр дүн гарч байгааг тэмдэглэх нь зүйтэй. Түүнээс гадна манай компаниудын хувьд ч гэсэн, Засгийн газрын байгууллагуудын хувьд ч гэсэн асуудлыг ойлгож, сайн хандаж байгаа явдал ажиглагдаж байгаа. Ялангуяа Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарыг сайн ажилласан гэж дүгнэж байгаад таатай байна. Тайлан гаргаж байгаагийн ач холбогдлыг олон нийтэд тайлбарлан ойлгуулах шаардлага байгаа. Тайлангийн гол зорилго бол иргэд, олон нийтэд хяналт тавих боломжийг олгоход оршиж байгаа юм. Энэ талаар гаргасан тайланд үндэслэн олон нийтэд мэдээлэх нь чухал юм. Энэ талаар учир дутагдалтай явж ирсэн нь үнэн. Энэ нь хөрөнгө мөнгөний асуудалтай ч холбоотой, ажлын зохион байгуулалтаас шалтгаалж байгаа зүйл ч бий. Бид дараа дараагийнхаа ажлын төлөвлөгөөнд энэ талаарх асуудлуудыг тусгаж явж байгаа, цаашид ч тусгаад явна, энэ талаар манай ажлын алба сайн анхаарч ажиллах ёстой. Материаллаг байдлын тухайд дахиад боловсронгуй болгох шаардлага байгаа нь харагдаж байна. Хэт жижиг юмаар оролдоод ажлын үр дүнд нөлөөлөх асуудал байх шиг байна. Тиймээс энэ талаар цаашид анхаарая. Засгийн газрын байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэхэд анхаарч ажиллах ёстой гэдэг дээр санал нэг байна. Ажлын албаны нэрний тухайд Ерөнхий сайдын ахалсан Үндэсний хороо гэдэг утга агуулгаараа ажлыг явуулахад ач холбогдоо өгдөг, өгөх ч ёстой. Гурван талын оролцоотой нь үнэн, гэхдээ Ерөнхий сайд ахалсан гэдэг утгаараа гурван талын оролцоотой гэдгийг алдагдуулаад явчихна гэж ойлгохгүй байна. Э.Сумъяа гуайн хэлсэн Ашигт малтмалын газраар Үндэсний зөвлөлд тайлбар хийлгүүлж оруулах нь зүйтэй гэснийг дэмжиж байна. Гол зөрчил гарч байгаа газар энэ болж байна. Тайлан гаргаж байгаа асуудал нь учир дутагдалтай, дээрээс нь өөрсдөө хандив тусламжийн асуудалд орооцолдсон явж байна. Үндэсний зөвлөлд тайланг оруулж танилцуулая. Тайлангийн үлдсэн шийдвэрлэгдээгүй зөрүүний асуудлыг Сангийн

сайдад уламжилж судлуулах, шийдвэрлэх арга замын талаар Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулуулая гэсэн байдлаар асуудлыг шийдвэрлэе.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1. Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайланг Үндэсний зөвлөлд ойрын үед танилцуулж батлуулахыг Ажлын хэсэгт (ахлагч Б.Долгор) зөвшөөрөв.

2. Тайлангийн явцад гарсан зөрүү бүрийг эцэслэн шийдвэрлэх талаар хүчин чармайлт гаргасан бүх талуудад талархал илэрхийлэв.

3. Тайлангаар гарсан шийдвэрлэгдээгүй зөрүүг Сангийн сайдад хүргүүлэн судлуулж, түүнийг шийдвэрлэх арга замын талаар Үндэсний зөвлөлийн хуралдаанд саналыг нь хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгорт зөвлөв.

4.Хандив, тусlamжийн зөрүүг үүсгэсэн Ашигт малтмалын газар, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны тайлбарыг гаргуулж Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзэв.

Б.Долгор-За ингээд дараагийн асуудалдаа ороё.

**II.ХЭЛЭЛЦСЭН нь:** “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын болон Ерөнхий сайдын захирамжийн төсөл

Б.Долгор энэ талаар Э.Сумъяа танилцуулна.

Засгийн газрын ахлах референт, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа: За та бүхэнд тогтоолын болон Ерөнхий сайдын захирамжийн төсөл болон танилцуулгын төслийг тараасан байгаа. Монгол Улс ОУИТБС-ын шаардлагыг хангасан буюу хэрэгжүүлэгч 4 дэх орон болсон. Үүнээс гадна ОУИТБС-ын дунд хугацаа (2010-2012)-ны стратегийг боловсруулж, Үндэсний зөвлөлөөр батлуулсан. Иймд ОУИТБС-ын талаар Засгийн газраас гарган мөрдөж байгаа бодлого, шийдвэрийг өөрчилж дараагийн үе шатанд шилжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байгаа юм гээд Тогтоолын болон Ерөнхий сайдын захирамжийн төслийг тайлбарлан танилцуулав. Тэрээр төсөлд гишүүдээс өгөх саналыг заавал бичгээр авна гэв /Танилцуулгыг хавсаргав/.

Б.Долгор: Асуулт байна уу?

Б.Жанцан: Одоо бид ямар байгууллагын төлөөлөл байгаа вэ?

Э.Сумъяа: Одоо бол Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан компаниудын төлөөллөөр танайх ажиллаж байгаа. Оролцогч нэг талын төлөөлөл мөртлөө тал талд өөр өөр асуудал яриад баймааргүй байгаа юм. Тухайлбал Уул уурхайн ассоциаци нэг юм яриад, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо нэг юм яриад байх нь зохисгүй байна. Зүй нь бол та бүхэн компанийгайгаа нэгдэж ажиллах ёстой.

Б.Жанцан: Одоогийн энэ ажлын хэсгийг татан буулгаж байгаа гэсэн үг үү?

Э.Сумъяа: Татан буулгаагүй, шинээр зохион байгуулж байна гэсэн үг.

Б.Долгор: Үндэсний зөвлөл, түүний дор ажлын хэсэг, тэгээд ажлын алба гэж байгаа. Энэ бүтэц бол өөрчлөгдхүй. Доторх бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа гэсэн үг. Ер нь бол ийм бүтэц сүүлийн үед чухал, сайн, үр дүнтэй хэлбэр байна гэж үзэж байгаа. Тиймээс бид уламжлалт энэ хэлбэрээ хадгалаад, төлөөллөө өргөжүүлээд мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулах гэсэн үзэл баримтлалтай байгаа. За өөр асуулт байна уу?

А.Батпүрэв: Хуучин бүрэлдэхүүнээр 3 талын төлөөлөл тэнцүү байсан. Одоо бол Үндэсний зөвлөлд төрийн байгууллагуудын төлөөлөл 60 хувь, нөгөө хоёр тал маань 20, 20 хувийг бурдүүлэх болж байгаа юм байна. Энэ ямар учиртай вэ? Ер нь тэнцүү төлөөлөлтэй байсан нь зүйтэй биш үү.

Э.Сумъяа: Төсөлд одоо байгаа төлөөллийн тоог яг хэвээр нь тавьсан. Санал байвал өгч болно, өөрчилж болно. Гэхдээ олон улсад бол Үндэсний зөвлөл шийдвэр гаргадаг, хариуцлага хүлээдэг гэдэг утгаараа Засгийн газар давуу байж болно гэж үздэг юм билээ. Ажлын хэсгийн тухайд Засгийн газрын төлөөлөл дээр 1 байгууллага нэмэгдсэн байгаа, түүнээс хуучин 8, 8 гэсэн төлөөлөлтэй байсан.

Б.Батболд: Тухайн байгууллагаа төлөөлж 1 хүн хуралдаанд тогтмол суух ёстой юмуу, төлөөлж ирж буй хүмүүс нь солигдоод суугаад байж болох юмуу? Солигдоод ээлжлээд сууна гэхээр тухайн ажлын хэсгийн хуралдаанд ярилцсан асуудал, процессыг тухайн хуралд суусан хүн цааш дамжуулахгүй, харилцаа холбоо алдагдах байдал ажиглагдаж байна. Үүнийг яах вэ?

Б.Долгор: Энэ бол ажлын зохион байгуулалтын асуудал, цаашид анхаарах ёстой. Гишүүдийг хариуцлагажуулах талаас анхаарах ёстой юм байна.

Н.Алгаа: Батпүрэвийн хэлдэг төлөөлөл тэнцүү байх асуудал нэг асуудал. Харин энэ төлөөллийг төлөөлж хуралд суух хүний тухайд тухайн хүний сайн, муугийн асуудал. Тиймээс бид үүнийг шийдэх механизмтай байх ёстой. Өөрөөр хэлбэл тогтоол гаргаж хүний нэр зоохгүйгээр, тухайн байгууллагыг төлөөлөн ирж буй хүн хуралдаа идэвхгүй суувал тухайн төлөөлөл тэр хүнийг солих эрхийг нь олгож байна гэж ойлгож байна. Миний хувьд тогтоолын төслөөр их зөв механизмд орох нээ гэж ойлгож байна. Тийм үү?

Э.Сумъяа: Яг зөв. Хариуцлагаа оролцогч тухайн тал хүлээнэ гэсэн үг. Хоёрдугаарт Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын тогтоолоор, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын захирамжаар томилдог. Жил бүр тогтоол, захирамжид өөрчлөлт оруулна гэдэг бол тоглоом биш. Компанийн болон иргэний нийгмийн удирдлагад жил бүр л өөрчлөлт орж, улмаар бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод байгаа тул үүнийг цэгцлэх зорилгоор энэ тогтоолын төслийг боловсруулсан юм.

Б.Долгор: За санал байна уу?

Б.Болдбаатар: Бид орон нутгийн түвшинд энэ санаачлага хэр хэр: байна вэ гэдгийг шалгах үүднээс Нээлттэй нийгэм форумтай хамт Оюутолгой, Тавантолгой уурхай оршдог сумын түвшинд тайлан гаргах гэж ба Тэгэхээр энд гарсан зөрчил дутагдлыг ажлын хэсгийн хуралд танилцуулж зөрчил дутагдлыг төрийн байгууллагаас хянаж шалгах боломжтой юм

Э.Сумъяа: Ажлын хэсгийн ажиллах журам гэж байгаа. Тэр журам дээр н тавьсан санал чинь танай үүрэг болсон байгаа. Хоёрдугаарт, орон нутгийн тайлан гаргах ажлыг Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны тайландаа хавсралт болгоод оруулаяа гэж иргэний нийгмийн эвсэл Дорждарь санал тавьж, зардлыг Нээлттэй нийгэм форумаас гаргасан нөхцөлд аудитын консерциумтай байгуулж гэрээнд нэмэлт болгон оруулах санал тавьяа гэж зөвшилцсэн байгаа.

Б.Долгор: За өөр санал байна уу?

Ж.Ивээлэн: Энэ тогтоолын төслийн 9-ийн в, г-д заалтаар санал аваад талаар бидэнд албан бичгээр хандах нь зөв юм болов уу гэсэн саналтай байна.

Э.Сумъяа: Ер нь бичгээр санал авна.

Я.Пурвээ: Ажлын хэсгээс албан бичгээр хандаад, бүх газрууд саналаа бичгээр өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Э.Сумъяа: Ажлын хэсгийн түвшинд төслийн талаар албан бичиг бичиж санал авахгүй. Та бүхэн ажлын хэсэгт байгууллагуудаа төлөөлөх бүрэн эрхтэйгээр энд сууж байгаа. Тогтоолын төсөл дээр ажлын хэсгийн гишүүд та бүхний л саналыг авах гэж байгаа юм. Дараа нь Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулж, улмаар Засгийн газрын хуралдаанд оруулахын өмнө бүх сайд нараас албан бичгээр санал авна. Өөрөөр хэлбэл энэ тогтоолыг агуулгыг өртгөтгөх, найруулгын хувьд л та бүхнээс ажлын хэсгийн гишүүний хувьд санал авч байгаа юм.

Т.Цэцэгням: За тэгвэл саналаа хэлзэе. Миний хувьд энэ ажлыг аваад 2 сар болж байна. Аудитын компанид дэмжлэг үзүүлж ажиллалаа. Олборлох үйлдвэрлэлийн ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий, газрын тосны тусгай зөвшөөрөл бүхий компаниуд болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нарын талаарх мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлсэн регистрийн дугаараар тайлан гаргаж ажиллахыг нийт байгууллагуудын ажилтнуудад үүрэг болгох шаардлагатай байна. Энэ талаар тогтоолын төсөлд оруулах гэсэн саналтай байна. Хоёрдугаарт, санаачлагын тайланг улсын хэмжээнд нэгтгэж байгаа Татварын ерөнхий газрын мэдээллийн сүлжээг өргөтгэн сайжруулж, программ хангамж бий болгож, аймаг нийслэл, сум, дүүрэгт төвлөрсөн татвар, төлбөр, хураамж зэрэг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрч байгаа орлогын мэдээг үнэн зөв гаргах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах гэж холбогдох заалтыг найруулмаар байна. Дараагийн нэг санал бол зөвхөн Татварын ерөнхий газрын мэдээллийн бааз, программ хангамжийг сайжруулах асуудал биш юм. ОҮИТБС-ын тайланг гаргаж байгаа яам, агентлаг, орон нутгийн байгууллагууд, олборлох үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжийн мэдээллийг нэгтгэх зорилгоор санхүүгийн тайланд нь нэмэлт хавсралт оруулах

гэсэн саналтай байна. Үүнээс гадна улсын бүртгэлийн газрын баазад суурилсан вэб хандлагатай программ бий болгох гэсэн саналтай байна.

Б.Долгор: За чухал саналууд гарч байна. Өөр саналтай хүн байна уу?

А.Батпүрэв: Зарчмын хувьд талуудад нь эрхийг олгож байгаа тогтоолын төслийг дэмжиж байна. Харин оролцогч талуудын бүрэлдэхүүний харьцааг эргээд хараарай гэж хүсэх байна. Хоёрдугаарт, орон нутгийн түвшинд байгуулах салбар зөвлөлийн үүрэг, хариуцлагын зүйл заалтыг илүү дэлгэрэнгүй зааж өгөө гэсэн саналтай байна. Ингэснээр энэ санаачлага орон нутгийн түвшинд хэрэгжих цаашдын нэг том алхам болох болов уу гэж бодож байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1. Засгийн газрын тогтоолын төсөл болон Ерөнхий сайдын захирамжийн төсөлд хуралдаан дээр Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусган Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгорт зөвшөөрөв.

**III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг 2012 онд хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцооны тухай**

Б.Долгор: За та бүхэнд танилцуулгыг хүргүүлсэн байгаа тул шууд асуулт байвал асуугаад явая.

Б.Батболд: Сурталчилгааны зардал ерөөсөө байхгүй байна. Эсхүл өөр газар шингээд орсон юмуу?

Ш.Цолмон: 2011, 2012 онуудад манай санаачлага Дэлхийн банкнаас 250,000 ам.доллар болон Европын сэргээн босголтын банкнаас 450,000 ёврогийн тусlamж дэмжлэг авна. Эдгээр санхүүжилтээр хууль эрх зүйн орчинг бий болгох, сургалт, семинар зохион байгуулах, харилцаа холбоо, сурталчилгааны чиглэлийн зэрэг гол томоохон ажлууд хийгдэнэ. Тэгэхээр манай санаачлагын сурталчилгааны зардлууд гадны тусlamжаар санхүүжүүлэгдэх тул давхардуулахгүй гэдэг үүднээсээ улсын төсөвт тусгаагүй болно.

Н.Алгаа: Ер нь бол Дэлхийн банкнаас бид хамаараад баймааргүй байна. Цаашид тэр ажлын албаны зардлыг мөн адил улсын төсөвт тусгаад оруулах хэрэгтэй. Тийм учраас өөрсдөө улсын төсвөөс санхүүждэг болмоор байна.

Б.Батболд: Сурталчилгааны чиглэлээр өөрсдөө тодорхой хэмжээний мөнгө тусгасан нь зөв байх.

Э.Сумъяа: Нэг тайлбар хэлзэе. Төсөв, зээл тусlamжийг Сангийн яам зохицуулж байгаа. Өөрөөр хэлбэл хаанаас юуг санхүүжүүлэх вэ гэдгийг Сангийн сайд зохицуулж байгаа. Одоогийн байдлаар аудитын зардлаа Засгийн газар гаргая гэсэн чиглэлтэй явж байгаа. Та бүхний саналыг алхам алхмаар төсөвт тусгаад явъя гэсэн саналтай байна.

Б.Долгор: Тов тодорхой сайн санал байна.

А.Батпүрэв: Төсөв дээр гишүүдийн урамшуулал оржээ. Бид нар цалин авдаг болох нь. Нэг удаад 25000 төгрөг гээд үүний хэрэг байна уу? Хувь хүмүүсийн санаачлага байх, мөнгөний төлөө уралдуулмааргүй байна. Энэ зардлыг өөр зардлууддаа шингээгээд нэмээд явбал ясан юм бэ гэсэн саналтай байна.

Б.Болдбаатар: Нэг зарлалын чанартай зүйл хэлэе. Одоо Ашигт малтмалын тухай хуульд санал өгөх боломж байгаа юм билээ. Тэгэхээр ОҮИТБС-ын ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөсөө хуулийн төсөлд санал оруулж болохгүй юмуу гэсэн саналтай байна.

Б.Долгор: Шаардлагатай гэж үзвэл хуулийн төсөлд тусгах саналаа ажлын хэсгээрээ, үндэсний зөвлөлөөрөө, аль эсхүл та бүхэн бие дааж явуулж болно. Тэр хурлын урамшуулалт гэдгийг тэр хэвээр нь хэлэлцүүлээд үзье гэж бодож байна.


**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг 2012 онд хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцооны талаар хуралдаан дээр Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг судлан тусгаж Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Ажлын алба (зохицуулагч Ш. Цолмон)-нд зөвшөөрөв.

Б.Долгор-За ингээд ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа дуусгая. Та бүхэнд баярлалаа.

Ажлын хэсгийн хурал 19 цаг 30 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
Ажлын хэсгийн ахлагч



Б.Долгор

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн



Б.Дэлгэрмаа

А.Батпүрэв: Төсөв дээр гишүүдийн урамшуулал оржээ. Бид нар цалин авдаг болох нь. Нэг удаад 25000 төгрөг гээд үүний хэрэг байна уу? Хувь хүмүүсийн санаачлага байх, мөнгөний төлөө уралдуулмааргүй байна. Энэ зардлыг өөр зардлууддаа шингээгээд нэмээд явбал ясан юм бэ гэсэн саналтай байна.

Б.Болдбаатар: Нэг зарлалын чанартай зүйл хэлэе. Одоо Ашигт малтмалын тухай хуульд санал өгөх боломж байгаа юм билээ. Тэгэхээр ОҮИТБС-ын ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөсөө хуулийн төсөлд санал оруулж болохгүй юмуу гэсэн саналтай байна.

Б.Долгор: Шаардлагатай гэж үзвэл хуулийн төсөлд тусгах саналаа ажлын хэсгээрээ, үндэсний зөвлөлөөрөө, аль эсхүл та бүхэн бие дааж явуулж болно. Тэр хурлын урамшуулалт гэдгийг тэр хэвээр нь хэлэлцүүлээд үзье гэж бодож байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг 2012 онд хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцооны талаар хуралдаан дээр Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг судлан тусгаж Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Ажлын алба (зохицуулагч Ш. Цолмон)-нд зөвшөөрөв.

Б.Долгор-За ингээд ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа дуусгая. Та бүхэнд баярлалаа.

Ажлын хэсгийн хурал 19 цаг 30 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
Ажлын хэсгийн ахлагч



Б.Долгор

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн



Б.Дэлгэрмаа